



МОНГОЛ УЛС  
ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2025 оны 04 сарын 30 өдөр

Дугаар А/266

Чойбалсан

Г “Хүн болох багаасаа” сургалтын төсөлд Г  
захиалагчийн хяналт тавих дэд ажлын  
хэсгүүдийг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.3 дахь заалт, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.4.1, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.5, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.5, 8.1.7, Захиргааны ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.7, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны “Хүн болох багаасаа” төсөл батлах тухай 13.17, 13.18, 13.19 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Хүн болох багаасаа” хүүхдийн спорт, гадаад хэл, авьяас сургалтын төслүүдийн хэрэгжилтэд захиалагчийн хяналт тавих дэд ажлын хэсгүүдийг нэгдүгээр хавсралтаар, ажлын удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Сургалтын үйл ажиллагааг гүйцэтгэгчдэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж, батлагдсан хөтөлбөр, журам, гэрээний дагуу гүйцэтгэж буй эсэхэд хяналт тавьж, биелэлтийг улирал тутамд аймгийн Хүүхдийн төлөө зөвлөл, Байнгын ажлын хэсэгт тайлагнаж ажиллахыг дэд ажлын хэсгүүд (Ж.Сайхангэрэл, Ч.Ариунаа, Б.Чимэддорж)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Ч.Ганбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ЁЛ

My computer D/ Zakhiramj  
2125010690

Аймгийн Засаг даргын 2025 оны  
04 дүгээр сарын 30-ны өдрийн  
А/266 дугаар захирамжийн нэгдүгээр  
хавсралт



**"ХҮН БОЛОХ БАГААСАА" ГАДААД ХЭЛНИЙ СУРГАЛТЫН  
ТӨСЛИЙН ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТЫН ДЭД  
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ахлагч:	Ч.Ариунаа	-Аймгийн Боловсролын газрын дарга
Нарийн бичиг:	Ө.Болорчимэг	-Аймгийн Боловсролын газрын Гадаад хэлний боловсрол хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	Г.Золбаяр	-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч (зөвшилцсөнөөр)
	Э.Нарангарав	-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, Төсөв, санхүү, эдийн засгийн бодлогын хорооны дарга (зөвшилцсөнөөр)
	П.Бадамцэцэг	-“Байгаль орчин, нийгэм, эдийн засгийн судалгаа хөгжлийн амжилтын зөвлөх төв” НҮТББ-ын Удирдах зөвлөлийн дарга
	Б.Оюунчимэг	-Иргэний төлөөлөл

---oOo---

“ХҮН БОЛОХ БАГААСАА” АВЪЯАС СУРГАЛТЫН  
ТӨСЛИЙН ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТЫН ДЭД  
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ахлагч:	Ж.Сайхангэрэл	-Аймгийн Хүүхэд, Гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
Нарийн бичиг:	Д.Цэрмаа	-Аймгийн Хүүхэд, Гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын ахлах мэргэжилтэн, Хүүхдийн эрхийн улсын байцаагч
Гишүүд:	О.Гүнтамир	-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, Нутгийн удирдлагын бодлогын хорооны дарга (зөвшилцсөнөөр)
	Х.Энхтунгалаг	-Либерал Эмэгтэйчүүдийн Оюуны сангийн Дорнод аймаг дахь салбарын тэргүүн
	Н.Оюунханд	-Иргэний төлөөлөл

---oOo---

“ХҮН БОЛОХ БАГААСАА” СПОРТ СУРГАЛТЫН  
ТӨСЛИЙН ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТЫН ДЭД  
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ахлагч:	Б.Чимэддорж	-Аймгийн Биеийн тамир, спортын газрын дарга
Нарийн бичиг:	Л.Наранбаатар	-Аймгийн Биеийн тамир, спортын газрын ахлах мэргэжилтэн
Гишүүд:	З.Ганбат	-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч (зөвшилцсөнөөр)
	Б.Хонгорзул	-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч, Уул уурхай, эрдэс баялгийн хорооны дарга (зөвшилцсөнөөр)
	Б.Урансувд	-Дорнод аймгийн Социал демократ эмэгтэйчүүдийн холбооны тэргүүн
	Ж.Тайван	-Иргэний төлөөлөл

---oOo---

Аймгийн Засаг даргын 2023 оны  
04 дүгээр сарын 30-ны өдрийн  
А/266 дугаар захирамжийн хоёрдугаар  
хавсралт



## ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТ ТАВИХ ДЭД АЖЛЫН ХЭСГИЙН АЖИЛЛАХ УДИРДАМЖ

### Дэд ажлын хэсгийн чиг үүрэг:

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 13/17, 13/18, 13/19 дүгээр тогтоолоор батлагдсан "Хүн болох багаасаа" хүүхдийн авьяас, гадаад хэл, спортын сургалтын төслүүдийн хэрэгжилтийн явц, үр дүнг Байнгын ажлын хэсэг, Хүүхдийн төлөө зөвлөлд тогтмол танилцуулах

### Дэд ажлын хэсгийн хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- "Хүн болох багаасаа" төсөл хэрэгжүүлэх журмын хэрэгжилтэд хяналт тавина.
- Захиалагчийн хяналт тавих ажлын дэлгэрэнгүй төлөвлөгөө, төсвийн задаргааг Засаг даргаар батлуулж, хэрэгжилтийг төсөл хэрэгжүүлэх Байнгын ажлын хэсэгт тогтмол тайлагнаж байна.
- Захиалагчаас төсөл хэрэгжүүлэгч нартай байгуулсан гэрээний хэрэгжилтийн явц, үр дүнд захиалагчийн хяналт тавих
- Төсөлд шалгарсан хуулийн этгээд нь сургалт, дугуйланд хамрагдах хүүхдүүдийг тухайн шалгарсан багцынхаа хамран сургах тойргийн дагуу бүртгэж хамруулах бөгөөд, дэд ажлын хэсгүүдийн зүгээс хүүхдүүдийн хамрагдалтад хяналт тавьж, зөвлөн туслах
- Батлагдсан төлөвлөгөөний даргуу аймгийн төв, сумдад хэрэгжиж буй төслүүдийн үйл ажиллагаатай газар дээр нь очиж ажиллан, үнэлэлт дүгнэлт өгөх
- Төсөл хэрэгжүүлэгч нараар төсөл эхлэх үеийн гарааны, явцын болон үр дүнгийн судалгааг хийлгэж, дэлгэрэнгүй тайлан авах
- Төсөлд хамрагдаж буй хүүхдүүд, тэдний эцэг эх, асран халамжлагч, багш нартай биечлэн уулзаж, санал хүсэлтийг сонсох
- Төслийн санхүүжилтийг "Санхүүжилт олгох" гэрээнд заасны дагуу зарцуулж буй эсэхэд хяналт мониторинг хийх, зөрчил гарсан тухай бүрд арилгуулах
- Төслийн хүрээнд зохион байгуулж буй уралдаан тэмцээн, тайлан өдөрлөг болон бусад арга хэмжээний зохион байгуулалт, хэрэгжилт, үр дүнд хяналт тавих
- Захиалагчийн хяналт тавих ажлын явцын болон үр дүнгийн тайланг аймгийн Засаг даргын 2023 оны А/191 дүгээр захирамжаар байгуулагдсан Байнгын ажлын хэсэгт болон аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлд танилцуулах